



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/ҮҮ

Улаанбаатар хот

□ Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн □
орон тооны бус салбар зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/502 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөл"-ийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, өвчлөл эндэгдлийг бууруулах зорилгоор бодлогын хэрэгжилтэд салбар дундын оролцоог хангах, "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд"-ийн 2023-2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхийг "Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөл"-д үүрэг болгосугай.


3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг даргын эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 12 дүгээр сарын 18 ны өдрийн
17.18 дугаар захирамжийн хавсралт



ЭХ, ХҮҮХЭД, НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ОРОН ТООНЫ БУС САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Салбар зөвлөлийн
дарга:

Орлогч дарга:
Гишүүд:

Засаг даргын эдийн засаг, нийгмийн
хөгжлийн асуудал хариуцсан орлогч
Эрүүл мэндийн төвийн дарга
Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Санхүү,
төрийн сангийн хэлтсийн дарга
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний
хэлтсийн дарга
Боловсролын хэлтсийн дарга
Гэр бүл, хүүхэд залуучуудын
хөгжлийн хэлтсийн дарга
Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
Нийгмийн даатгалын хэлтсийн дарга
Эрүүл мэндийн төвийн Чанарын
менежер

Нарийн бичгийн
дарга:

Засаг даргын Тамгын газрын Эрүүл
мэнд, биеийн тамир хариуцсан
мэргэжилтэн